



МОНГОЛ УЛСЫН  
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН  
ТУШААЛ

2024 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 8/75

Улаанбаатар хот

Батлан хамгаалах салбарын хүүхэд  
хамгааллын чиглэлээр баримтлах бодлого,  
чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Батлан хамгаалах яам, харьяа байгууллага, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, удирдах газар, харьяа нэгтгэл, анги, салбар нь офицер, ахлагч, ажилтан албан хаагчдаараа дамжуулан гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдэд ээлтэй орчин бурдүүлэх, алба хаагчдын ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийг хавсралтаар баталсугай.
- Дээрх бодлогын баримт бичигтэй уялдуулан "Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг"-ийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулж, мөрдөж ажиллахыг Зэвсэгт хүчний Жанжин штаб (хошууч генерал С.Ганбямба), яамны харьяа байгууллагын дарга, захирал наарт үүрэг болгосугай.
- Энэхүү бодлогын баримт бичгийг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Эцэг, эхийн зөвлөл (хурандаа Ж.Банзрагч)-д даалгасугай.

САЙД

Г.САЙХАНБАЯР



1302100192

Батлан хамгаалахын сайдын 2024 оны  
02 дугаар сарын 11-ны өдрийн  
дугаар тушаалын хавсралт

БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН  
БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Батлан хамгаалах яамны харьяа аж ахуйн нэгж, байгууллага, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, анги, салбарууд нь Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг, Эцэг эхийн зөвлөл байгуулах зөвлөмж, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасны дагуу ажилтан албан хаагчийн ажил, амралтын цагийг зохицуулах, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн дотоод журамд тусгах замаар ажилтан албан хаагчийн хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ.

Хоёр. Зорилго

2.1.Батлан хамгаалах салбар нь алба хаагчдаараа дамжуулан гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, үүрэг хариуцлагаа биелүүлэхэд чиглэсэн сургалт нөлөөллийн ажил, арга хэмжээг зохион байгуулж, салбарын хэмжээнд нэгтгэл, анги, байгууллагын нөөц, онцлогт нийцүүлэн хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж ажиллахад оршино.

Гурав. Үндсэн зарчмууд

3.1.Салбарын алба хаагчдын хүүхдийн эрх, язгуур эрх ашиг, тэдний аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, хүүхдийн онцгой халамж, туслалцаа авах эрх зүйн орчныг бүрдүүлэх.

3.2.Хүүхдийн эсрэг хүчирхийлийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрөхгүй.

3.3.Аливаа үйл ажиллагаанд хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл, үл хайхрах байдал, осол гэмтэлд өртүүлж болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллана.

Дөрөв. Хамрах хүрээ

4.1.Энэхүү бодлогын баримт бичиг нь Батлан хамгаалах яамны харьяа аж ахуйн нэгж, байгууллага, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, удирдах газар, харьяа нэгтгэл, анги, салбарын бүх офицер, ахлагч, түрүүч, байлдагч, сонсогч болон ажилтан албан хаагчдад хамаарна.

Тав. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

5.1. Батлан хамгаалах яамны харьяа аж ахуйн нэгж, байгууллага, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, анги, салбарын захирагч, дарга, удирдлага, ажил олгогч нь офицер, ахлагч, ажилтан

албан хаагчийн ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөрийн харилцааны уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангах.

5.2. Цэцэрлэгийн болон бага ангийн хүүхэдтэй офицер, ахлагч, ажилтан албан хаагч, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эх, хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай өрхийн гишүүнтэй ажилтан албан хаагч, өрх толгойлсон эцэг, эхийн ажиллах нөхцөлийг уян хатан болгож хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгуулж, мөрдүүлнэ. Үүнд:

5.2.1. богиносгосон цагаар ажиллах;

5.2.2. цахимаар ажиллах;

5.2.3. хүүхдээ цэцэрлэг, сургуульд хүргэж өгөх, авах боломжоор хангах;

5.2.4. шөнийн ээлжийн ажилд аль болох хуваарилахгүй байх;

5.2.5. цалингийн нэмэлт, урамшуулал дэмжлэг үзүүлэх;

5.2.6. харуул, хоногийн манаа, жижүүрийн ажилтай бие бүрэлдэхүүний цагийн хуваарийг уян хатан байдлаар бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр зохицуулалт хийх.

5.2.7. бусад дэмжлэгт хамруулах.

5.3. Салбарын хүүхдэд ээлтэй байгууллагын шалгуурыг салбарын хэмжээнд мөрддөг хууль тогтоомж болон Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжтой нийцүүлэн алба хаагчдын хүүхдийг хөгжүүлэх, эрхийг хамгаалах талаар төлөвлөгөө боловсруулж батлуулах.

5.4. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг", "Байгууллагад эцэг эхийн зөвлөл байгуулах зөвлөмж"-ийн дагуу яамны харьяа аж ахуйн нэгж байгууллага, Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, анги, салбар бүр офицер, ахлагч, ажилтнуудын гэр бүл, хүүхдэд чиглэсэн үйл ажиллагааг өөрийн байгууллагын нөөц, хэрэгцээнд түшиглэн зохион байгуулах "Эцэг эхийн зөвлөл" /цаашид Зөвлөл гэх/-ийг байгуулах. Үүнд:

5.4.1. Зөвлөлийн дарга төлөвлөгөөг 1 жилийн хугацаатайгаар гарган хамт олноор хэлэлцүүлж, батлах бөгөөд биелэлтийг байгууллагын удирдлага, нийт хамт олонд тайлагнах;

5.4.2. Байгууллага хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийн үнэлгээ хийж үр дүнд үндэслэн сайжруулж, мөрдүүлэх;

5.4.3. Байгууллагын мэдээллийн самбар цахим хуудаст байршуулж, сурталчлан таниулах;

5.4.4. Байгууллагын офицер, ахлагч, ажилтан албан хаагчийн гэр бүл, хүүхдийн нөхцөл байдлын судалгаа хийж, хэрэгцээнд суурилсан сургалт, бодит дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн байгууллагын үйлчилгээнд холбон зуучлах.

5.5. Батлан хамгаалах яам, харьяа аж ахуйн нэгж, байгууллага, Зэвсэгт хүчний Жанжин штаб, нэгтгэл, анги, салбарын сургуулийн жилийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөндөө тусгах замаар алба хаагчдадаа зориулж сургалт нөлөөллийн ажил арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

5.5.1 Офицер, ахлагч, ажилтан, албан хаагчийн хүүхдийн сурч боловсрох, хөгжил, хамгааллыг дэмжих, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх, хүүхдэд ээлтэй байгууллага хамт олон болох санаачилгыг өрнүүлж, байгууллагын удирдлагатай хамтран ажиллах;

5.5.2. Мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, ажилтан, албан хаагч, тэдний гэр бүл, хүүхдэд зориулсан соён гэгээрүүлэх, хөгжүүлэх, чадавхжуулах сургалт, сэтгэл зүйн зөвлөгөөнд хамруулах.

5.6. Байгууллага бүр өөрийн боломж, ажилтнуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн санал санаачилгыг өрнүүлж байгууллагын нөөцөд тулгуурлан хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ. Тухайлбал:

5.6.1 Хүүхдийн хөгжих, эрүүл аюулгүй, хараа хяналттай байхад үргэлж анхаарч, байгууллагын дэргэдэх цэцэрлэг, өдөр өнжүүлэх төв, хүүхдийн өрөө, ажилтан, албан хаагчийн амрах өрөө байгуулах;

5.6.2. байгууллагын дэргэд цэцэрлэг, өдөр өнжүүлэх, хүүхдийн өрөө, ажилтны амрах өрөө байгуулах боломжгүй анги, салбарууд улсын болон хувийн цэцэрлэг, өндөр өнжүүлэх төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллах;

5.6.3. Байгууллагын гадаад, дотоод орчны эрсдэлийн үнэлгээ хийх, илэрсэн эрсдэлийг арилгах арга хэмжээг байгууллагын хэмжээнд зохион байгуулах;

5.6.4. Байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа нь хүүхдэд хор хөнөөл учруулж болзошгүй эрсдэл байгаа эсэхэд тогтмол үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах, арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх.

Зургаа. Офицер, ахлагч, ажилтан албан хаагчдын хүүхэд хамгааллын ёс зүйн дүрэм

6.1. Байгууллагын удирдлага, офицер, ахлагч, ажилтан албан хаагч бүр ажлын байр, гэр бүл, нийгмийн бүхий л орчинд зохисгүй зан үйл гаргахгүй байхад анхаарч, хүүхэд хамгааллын ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

Офицер, ахлагч, ажилтан албан хаагч	Байгууллага
Ёс зүйн дүрэмд заавал тусган хориглох зүйл	<ul style="list-style-type: none"> <li><input checked="" type="checkbox"/> Хүүхдийг цохих, зодох, тусгаарлах зэргээр бие махбодын хүчирхийлэл үйлдэх</li> <li><input checked="" type="checkbox"/> Хүүхдийг гутаах, ичээх, доромжлох, дорд үзэх, нэр хоч өгөх, сэтгэл зүйн дарамт учруулах зэргээр сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэх</li> <li><input checked="" type="checkbox"/> Хүүхэд, гэр бүлийн эсрэг бүх төрлийн хүчирхийл үйлдэх</li> <li><input checked="" type="checkbox"/> Бусдыг садар самуунд уруу татсан тоглоом тоглох, шалиг үг ярих</li> <li><input checked="" type="checkbox"/> Хүүхдийн дэргэд хараал хэлэх, бүдүүлэг үг хэрэглэх</li> <li><input checked="" type="checkbox"/> Хүүхдийг ялгаварлан харилцах</li> <li><input checked="" type="checkbox"/> Хүүхэд хүчирхийлэлд өртсөн, аюултай нөхцөл байдалд орсон тохиолдолд мэдээлэхгүй орхих</li> <li><input checked="" type="checkbox"/> Зохисгүй хувцаслах, бэлгийн дур сонирхол төрүүлэхүйц байдал гаргах</li> <li><input checked="" type="checkbox"/> Чанарын баталгаагүй, муудсан, хориглосон, чихэрлэг хоол хүнсээр хангах</li> <li><input checked="" type="checkbox"/> Байгууллагын хүүхэд хамгааллын бодлогыг зөрчиж байгаа нь мэдэгдсэн, сэжиглэгдсэн боловч мэдээгүй мэт өнгөрөөх, нуун дарагдуулах</li> <li><input checked="" type="checkbox"/> Хүүхэд эрсдэлт нөхцөлд байгааг мэдсэн, ажигласан, таамагласан боловч мэдээлэхгүй байх</li> <li><input checked="" type="checkbox"/> Хүүхдийг ямар нэгэн хөдөлмөрт хөлслөх.</li> <li><input checked="" type="checkbox"/> Ажилтнууд насанд хүрээгүй хүүхдээр өөрийн хүүхдийг асуулах, гэрийн үйлчлэгч хийлгэх, хувийн бизнестээ олон цагаар туслуулах</li> <li><input checked="" type="checkbox"/> Оройн 18 цагаас хойших арга хэмжээнд хүүхэд оролцуулах</li> <li><input checked="" type="checkbox"/> Эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүй хүүхдийг урлаг, спортын үйл ажиллагаанд оролцуулах</li> <li><input checked="" type="checkbox"/> Гамшиг осол, уй гашуу тохиолдсон үед хүүхэд, насанд хүрэгчдийн эмзэг байдалд мэдрэмжгүй хандах</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li><input checked="" type="checkbox"/> Хүүхдийн зураг, дурс, мэдээллийг зөвшөөрөлгүй хувийн фэйсбүүк хуудас ба бусад нийгмийн сүлжээнд тавих</li> <li><input checked="" type="checkbox"/> Шөнийн цагаар эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүй хүүхдийг тээвэрлэх</li> <li><input checked="" type="checkbox"/> Цахим орчинд эцэг эхээс нь далдуур хүүхэдтэй харилцах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li><input checked="" type="checkbox"/> Эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийг ганцааранг нь машинаар авч явах</li> <li><input checked="" type="checkbox"/> Ёс заншил, шашны болон зан үйлийн хэлбэртэй үйл ажиллагаанд оролцуулах</li> <li><input checked="" type="checkbox"/> Зураг, мэдээллийг хувийн фэйсбүүк хуудас ба бусад хувийн нийгмийн сүлжээн дээр тавих</li> <li><input checked="" type="checkbox"/> Ажлын байр, хүүхдийн орчинд архи, тамхи мансууруулах эм бодис хэрэглэх</li> </ul>
--	--	--

---оОо---